



“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 4 сарын 23-ны өдөр

№ 25/01

Улаанбаатар хот

“Эм жи эл акуа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр эхлэв.

Тооллогын комисс ирцийн баталгаажуулалтыг Хувьцаа эзэмшигчийн хурлыг онлайн хэлбэрээр зохион байгуулах AGM систем ашиглан тархалтын мэдээтэй тулган бүртгэсэн. Ийнхүү бүртгэхдээ хувьцаа эзэмшигчийг бичиг баримт, Аж ахуйн нэгж бол компанийн гэрчилгээ, итгэмжлэлийн үндсэн дээр танин баталгаажуулж, хувьцаа эзэмшигчийг цахим системд бүртгүүлэн И-Монголиа /Хур, Дан/ систем ашиглан баталгаажуулалт хийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд санал өгөх боломжоор ханган ажилласан.

“Эм жи эл акуа” ХК нь нийт 327,555,616 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаатай бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 84.27 хувь буюу 276,033,088 ширхэг хувьцаа эзэмшиж буй 17 хувьцаа эзэмшигч оролцов. Хуралд оролцсон 8 хувьцаа эзэмшигч саналын хуудсыг ирүүлэн саналаа өгсөн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц 84.27 хувиар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр болов.

(Компанийн тухай хуулийн 69.1-т “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.”

Компанийн тухай хуулийн 69.2-т “Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн хувийг энэ хуулийн 69.1-д зааснаас дээгүүр тогтоож болно.”

“Эм жи эл акуа” ХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл кастодианаар дамжуулж, эсхүл цахимаар оролцсоноор хүчин төгөлдөр болно.” гэж тус тус заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хангагдсан гэж үзэв.)

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид:

№	Овог	Нэр	Хувьцааны тоо	Хувь	Регистр
1	СҮХБААТАР	ДАМДИНСҮРЭН	101	0.000031%	111054351922
2	ДЭМБЭРЭЛ	МӨНХТӨР	2	0.000001%	111022940547
3	ЭНХБОЛД	БИЛГҮҮН	28,104	0.008580%	850194912821
4	БААТАР	БАЯРЗУЛ	5,495	0.001678%	110746450394
5	МЯГМАРЖАВ	ШИГШЭЭ	21	0.000006%	112502780196
6	ГАНТУЛГА	ОТГОНБАЯР	513	0.000157%	112255340074

7	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК ХХК		2717681	0.829685%	6317839
8	БАТЦЭНГЭЛ	УНДРАЛ	21	0.000006%	110765902041
9	БАТБОЛД	МАРАЛГУА	892	0.000272%	110777602526
10	ГАНБОЛД	АРИУНТӨГС	2,924,840	0.892929%	112576460277
11	АЛТАНСОЁМБО	АНУЖИН	110	0.000034%	111933152664
12	ШАГДАРСҮРЭН	ЭНХБАЯР	5,747,130	1.754551%	112280661717
13	ТИ ЭМ ЭЛ ТРЕЙД ХХК		240,000,000	73.270000%	5676029
14	ГАЛХҮҮ	НАМХАЙДОРЖ	569	0.000174%	430109571734
15	ЖАДАМБА	ОЮУННЯМ	227	0.000069%	432890621308
16	ДОРЖ	МӨНХӨӨ	22,883,242	6.986063%	111936981957
17	САЙНБУЯН	БАТБАЯР	1,724,140	0.526366%	111024112348
	Нийт		276,033,088	84.27%	

Үүнээс итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн хуралд оролцсон хувьцаа эзэмшигч байхгүй.

Санал өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Овог	Нэр	Хувьцааны тоо	Хувь	Регистр
1	ЭНХБОЛД	БИЛГҮҮН	28,104	0.00858%	850194912821
2	ГАНТУЛГА	ОТГОНБАЯР	513	0.00016%	112255340074
3	БАТЦЭНГЭЛ	УНДРАЛ	21	0.00001%	110765902041
4	БАТБОЛД	МАРАЛГУА	892	0.00027%	110777602526
5	ТИ ЭМ ЭЛ ТРЕЙД ХХК		240,000,000	73.27000%	5676029
6	ГАЛХҮҮ	НАМХАЙДОРЖ	569	0.00017%	430109571734
7	ДОРЖ	МӨНХӨӨ	22,883,242	6.98606%	111936981957
8	САЙНБУЯН	БАТБАЯР	1,724,140	0.52637%	111024112348
	Нийт		264,637,481	80.79162%	

Цаасан хэлбэрээр санал өгсөн /цахим систем рүү саналыг оруулж нэгдсэн дүн гаргасан/, ирүүлсэн хувьцаа эзэмшигчид:

№	Нэр	Хувьцааны тоо	Хувь	Регистр
1	ТИ ЭМ ЭЛ ТРЕЙД ХХК	240,000,000	73.27000%	5676029
2	ДОРЖ-ийн МӨНХӨӨ	22,883,242	6.98606%	111936981957
	Нийт	262,883,242	80.25606%	

2025 оны Эм жи эл агуа ХК-ийн ээлжит хурлыг С.Санасэр нээв. Үүний дараа ТУЗ-ийн дарга С.Алтантуяа мэндчилгээ дэвшүүлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг танилцуулав. Үүнд:

- “Эм Жи Эл Акуа” ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах
- Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах
- Компанийн ногдол ашгийн бодлого, 2025 оны ногдол ашгийн шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчид доорх санал болон асуулга асуув.

Асуулт: 1

Voyage цэвэр усны онцлог, давуу тал юу бэ?

Хариулах ажилтан: “Эм Жи Эл Акуа” ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч Б.Бат-Оргил

Компани бумбатын рашааны 125 метрийн гүнээс усаа авдаг, Бумбатын рашааны судалтай байгалийн гүний усыг 6 давхар шүүлтүүрээр шүүн цэвэршүүлж хэрэглэгчдэд хүргэдэгээрээ давуу талтай.

Voyage брэнд нь хоёр категорийн 6 нэр төрлийн савлагаатай усыг үйлдвэрлэдэг. Цэвэр ус, шүтлэг ус.

Шүтлэг рН 8.5 усны онцлог давуу тал нь : Бумбатын рашааны судалтай байгалийн гүний усыг 6 давхар шүүлтүүрээр шүүн цэвэршүүлж байгалийн хужраар эрдэсжүүлэн хүний биед нэн шаардлагатай эрдэс элементүүдээр баяжуулж өгсөнөөр давуу талтай. Мөн рН 8.5- тай шүтлэг ус учраас ходоодны хүчлийг саармагжуулж, ходоодны үрэвсэл, улайлт, шархны эдгэрэлтийг түргэсгэдэг, цээж хорсолтыг намдаах, биеийн жин бууруулах зэрэг үйлчилгээтэй эрүүл мэндийн ус гэдгээрээ онцлог.

Асуулт: 2

Ханбогд буюу шинэ төслийн явцын ажлаа танилцуулана уу?

Хариулах ажилтан: “Ти Эм Эл Акуа” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Дашзэвэг

“Эм Жи Эл Акуа” ХК-ний охин компаниар “Ти Эм Эл Акуа” ХХК-ийг 2024.12 сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд байгуулсан ба усны нөөц бүхий газрын хайгуулын ажил 2024 онд хийгдсэн.

2025 оны 2 сард захирамж гарч үйлдвэрийн барилга угсралтын ажил эхлэхэд бэлэн болоод байна.

Одоогоор төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулсан бөгөөд зураг төслийн ажил болон барилын зөвшөөрөлтэй холбоотой ажлууд хийгдэж байна.



Бид уг төслийг **2025 оны 8-р сард** багтаан дуусгахаар төлөвлөж байна.

Асуулт: 3

2025 оны Q1 улирлын борлуулалтын гүйцэтгэл хэдэн хувьтай явж байна вэ?

Хариулах ажилтан: “Эм Жи Эл Акуа” ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч Б.Бат-Оргил

2025 оны жилийн борлуулалтын төлөвлөгөө 39.1 тэрбум төгрөг, 2025 оны эхний улиралд 4.7 тэрбум төгрөгийн төлөвлөгөөнөөс 4.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй 93%-н гүйцэтгэлтэй явж байна.

Санал 1

Танайх ХЭХ хурлаа үйлдвэрийн байран дээр хийж болох уу, Хувьцаа эзэмшигчдийг үйлдвэрийн үйл ажиллаатай танилцуулаад явах гэх мэт?

Хариулах ажилтан: “Эм Жи Эл Акуа” ХК-ийн ТУЗ хараат бус гишүүн С.Санасэр

Өнгөрсөн жилийн ээлжит бус ХЭХ-ийг бид танхимаар зохион байгуулсан. Энэ жил бид олон ХЭ хамруулах үүднээс онлайнаар зохион байгуулсан. Таны саналыг бид хүлээж авлаа. Үйлдвэрийн байртай танилцаад явах нь нээлттэй байгаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсаар дараах асуудлуудаар санал хураав. Үүнд:

1. “Эм жи эл акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ -ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах тухай;
2. “Эм жи эл акуа” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;
3. “Эм жи эл акуа” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудад хувьцаа эзэмшигчид ердийн аргаар санал өгөх байв. Үүнд:

1. “Эм жи эл акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ -ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах тухай;
2. “Эм жи эл акуа” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах тухай

Дээрх асуудлуудад хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсыг тоолох явцад бүх санал буюу 276,033,088 ширхэг хувьцаатай 17 хувьцаа эзэмшигчдийн санал хүчин төгөлдөр байсан ба хүчингүй саналын хуудас байгаагүй болно.

Хэлэлцэх асуудлаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн санал өгсөн байдал:

1. Саналын хуудсаар Компанийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ -ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах тухай асуудлаар хуралд оролцож байгаа

саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь зөвшөөрсөн, 0 хувь татгалзсан, 0 хувь түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
264,637,481.00	100%	0.00	0.00%	0.00	0.00%

- Саналын хуудсаар Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах тухай асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь зөвшөөрсөн, 0 хувь татгалзсан, 0 хувь түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
264,637,481.00	100%	0.00	0.00%	0.00	0.00%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 276,033,088 ширхэг хувьцаатай 17 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсон гишүүдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	С.Алтантуяа	10.08%	240,018,620
2	Х.Тэгшээ	10.08%	240,100,404
3	О.Сансар	10.08%	240,010,316
4	М.Дөлгөөн	18.72%	445,959,494
5	Л.Билгүүн	10.08%	240,014,252
6	С.Санасэр	10.73%	255,502,077

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдсон гишүүдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ч.Анхбаяр	10.08%	240,105,831
2	Д.Басандорж	10.08%	240,005,831
3	Г.Мөнх-эрдэнэ	10.08%	240,003,252

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын дүнг Тооллогын комисс дэгийн дагуу танилцуулав.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолыг хурлын дарга С.Санасэр уншиж танилцуулснаар хурлын үйл ажиллагаа өндөрлөв.

Хурлын дарга:

A handwritten signature in black ink, appearing to be "C. Sanasir".

/С.Санасэр/

Хувьцаа эзэмшигчдийн хурлын

тэмдэглэл хөтөлсөн ТУЗ НБД:

A handwritten signature in black ink, appearing to be "G. Namkhaidorj".

/Г.Намхайдорж/